



## ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №22

### **НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусын шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:**

2020 оны 12-р дугаар сарын 07-21 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Европын холбооны хэд хэдэн улс оронд шувууны аж ахуйд болон нүүдлийн шувуудад илэрсэн байна (Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусын тархалт болон вирусын хэлбэр).

### **ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 12-р дугаар сарын 07-21 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдээгүй.

### **ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

Шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол 1 шинээр бүртгэгдсэн байна. БНХАУ-н Жянсү мужийн 81 настай эмэгтэй өртсөн. 11-р сарын 16 наас өвчний шинж тэмдэг илэрч эхэлсэн ба шувууны аж ахуйд ажилдаг байсан. Эмнэлэгт эмчлэгдэж байгаад 11-р сарын 27 нас барсан. 2014 оноос хойш H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөл 25 бүртгэгдээд байгаа ба үүнээс 8 өвчтөн нь нас барсан.

### **ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 12-р дугаар сарын 07-21 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

### **ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 12-р дугаар сарын 07-21 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусын хүний тохиолдол бүртгэгдээгүй.

### **ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 12-р дугаар сарын 07-21 ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


**ДОЛОО. 2020 оны 12-р дугаар сарын 07-21 ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:**

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт болон вирус хэлбэр

№	Мэдээлсэн өдөр	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвшинж	Улс	Муж	Өртсөн нийт шувуудын тоо	Өртсөн шувуудын зүйл
1	11/12/2020	9/12/2020	H5N8	Ирланд	Нокананна	127	Цацагт хяруул
2	11/12/2020	24/10/2020	H5N8	Англи	Нортааллертон	25764	Тахиа
3	11/12/2020	1/12/2020	H5N8	Англи	Снетертон	30000	Тахиа
4	14/12/2020	8/12/2020	H5	Украин	Новоматвеевское	115	Тахиа
5	12/12/2020	8/12/2020	H5N8	Израйль	Жериш	18500	Цацагт хяруул
6	14/12/2020	20/10/2020	H5N8	Голланд	Хайзен	2	Гургуул
7	14/12/2020	23/11/2020	H5N8	Франц	Сайнт Армел	1	Brent Goose Branta bernicla
8	19/12/2020	11/12/2020	H5N8	Шотланд	Сандей	29	Тахиа

Эх сурвалж: [www.poultrymed.com](http://www.poultrymed.com), [Cidrap.umn.edu](http://Cidrap.umn.edu)

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт /зургаар/



**ДОЛОО. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:**

2020 оны 12-р дугаар сарын 07-21 ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн өвчлөлийн сэжигтэй, үхсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**

*Шувууны томуу хариуцсан баг*